

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2020.01.27 - 01.31

Ти Ди Би Капитал ҮЦК нь Монголын хөрөнгийн биржтэй шууд холбогдсон арилжааны системийг ашиглан үнэт цаасны арилжаанд хамгийн түргэн шуурхай оролцох боломжийг олгож байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт коронавирусийн дэлхийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөтэй холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа.

Nasdaq индекс хамгийн бага бууралттай байсан бол зэх зээлийн үнэлгээ багатай индексүүд хамгийн их бууралттай байлаа. 2020 оны 1-р сарын байдлаар Nasdaq зэрэг зарим индексүүд өсөлттэй байсан бол бусад индексүүд өсөлтгүй эсвэл буурсан үзүүлэлттэй байлаа.

Даваа болон Баасан гарагуудад хувьцааны ханшууд хамгийн их буурсан ба энэхүү бууралт нь вирусийн тархалттай холбоотой байлаа. Долоо хоногийн сүүлээр гэхэд ойролцоогоор 10,000 вирусийн халдварын тохиолдол бүртгэгдсэн байсан ба Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас энэхүү вирусийн тархалтаас үүдэн олон улсын онц байдал зарласан байна. АНУ-ын засгийн газраас иргэддээ БНХАУ-руу аялахаас зайлсхийхийг зөвлөж байгаа юм.

Европ: БНХАУ-д коронавирусийн хурдацтай тархалт дэлхийн эдийн засгийн өсөлтөд цохилт өгөх айдас төрүүлснээр Европын зах зээлд хувьцааны ханшууд унав. Европын STOXX Europe 600 индекс өнгөрсөн долоо хоногт 2.28% -аар буурсан бол ХБНГУ-ын экспортлогч компаниудаас бүрддэг DAX индекс 3.47%, Францын CAC-40 индекс 2.94% -аар буурлаа. Английн Төв Банкнаас мөнгөний бодлогод өөрчлөлт оруулахгүй гэсэн шийдвэр гарснаас хойш Их Британийн FTSE 100 индекс 3.95% буурсан байна.

Евро бүсийн эдийн засаг дөрөвдүгээр улирлын байдлаар хүлээгдэж байснаас удаашралтай өсөлттэй гарсан гэж Европын холбооны статистикийн алба мэдээлжээ. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 4-р улиралд 0.1%, жилийн 1.0% -ийн өсөлттэй байсан нь FactSet-ийн судалгаанд оролцсон эдийн засагчдын тооцоолоос арай доогуур байна. Шинжээчдийн үзэж байгаагаар Франц, Итали улсууд ДНБ-ий өсөлт буурсан гол шалтгаан байв. 4-р улиралд Францын эдийн засаг буурсан нь 2019 оны сүүлээр нийтийн салбарын ажилчид ажил хаялт зарласантай холбоотой юм.

Япон: Энэ долоо хоногт коронавирусийн улмаас үүсэх дэлхийн эдийн засгийн удаашралын айдсаас үүдэн Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. Эдийн засгийн сайд Ясутоши Нишимура, Японы компаниудын орлого, ашиг, үйлдвэрлэлийн гарцад вирусийн тархалт сөргөөр нөлөөлж болзошгүй гэж мэдэгджээ. Японы худалдааны тэргүүлэгч түнш болох БНХАУ-аас ирсэн жуулчдын тоо өнгөрсөн онд Японд ирсэн нийт жуулчдын гуравны нэг орчим хувийг эзэлж байсан бөгөөд тэдний зарцуулалт нь гадаадын иргэдийн нийт зарцуулалтын 40 орчим хувийг эзэлж байна.

БНХАУ: Цагаан сарын баярын амралтын өдрүүдийг Ухань коронавирусийн тархалттай холбоотой сунгаснаас үүдэн Хятадын зах зээл энэ долоо хоногт хаалттай байлаа.

Арилжаа 2020 оны 2-р сарын 3-ны өдрөөс эхлэн үргэлжлэх ба зах зээл хаагдахас өмнө Хонконгийн Hang Seng индекс 1-р сарын 20-ны оргил үеэс 9.5% -аар буурсан байсан байна.

Хөгжиж буй зах зээлийн хувьцаануудын ханш бууралттай байсан бөгөөд MSCI индекс 1-р сарын 29-ний өдрийг хүртэлх долоо хоногт 2.9% -аар буурсан байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,828.56	-0.90% ▼
Dow Jones	АНУ	28,256.03	-2.53% ▼
S&P 500	АНУ	3,225.52	-2.12% ▼
Nasdaq	АНУ	9,150.94	-1.76% ▼
S&P/TSX	Канад	17,318.49	-1.41% ▼
FTSE 100	Их Британи	7,286.01	-3.95% ▼
S&P/ASX 200	Австрали	7,017.20	-1.03% ▼
Nikkei 225	Япон	23,205.18	-2.61% ▼
Hang Seng	Хонг Конг	26,312.63	-5.86% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.12
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.40
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.62
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	107.96
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.41
DBM' 2023	USD	7.250%	106.42
TDBM' 2020	USD	9.375%	101.43
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	98.20

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.662	0.00 ▲
Libor 3M	1.751	-0.04 ▼
Libor 6M	1.745	-0.06 ▼
Libor 1YR	1.807	-0.07 ▼
US 2YR Bond	1.333	-0.12 ▼
US 3YR Bond	1.313	-0.11 ▼
US 5YR Bond	1.334	-0.12 ▼
US 10YR Bond	1.522	-0.12 ▼

Валютын ханш	2020.01.31	Өөрчлөлт
USD	2,751.57	0.08% ▲
CNY	396.67	0.08% ▲
EUR	3,034.57	-0.15% ▼
RUB	43.61	-2.00% ▼
KRW	2.31	-1.70% ▼
JPY	25.23	0.52% ▲
CAD	2,082.08	-0.56% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,589.16	1.12% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	18.04	-0.32% ▼
Зэс	USD/lb.	251.70	-6.22% ▼
Нүүрс	USD/MT	67.17	-1.98% ▼
WTI газрын тос	USD/bbl.	51.56	-4.85% ▼
Brent газрын тос	USD/bbl.	58.16	-4.17% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. XII	5.2%
Бодлогын хүү	2019. XII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. XII	11.02%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. XII	11.29%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. XII	4.75%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. XII	16.84%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. XII	10.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 47 компанийн 461.9 сая төгрөгийн 891,625 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Монгол даатгал” /CHE/ компанийн хувьцаа 74.89%-аар буюу хамгийн ихээр өсөж 214.08 төгрөг хүрч хаагдсан бол “Силикат” /SIL/ компанийн хувьцаа 20.63%-аар буурч 50.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

01-р сарын 31-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,665.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,828.56 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.90%-аар буурсан байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	461.9	
Зах зээлийн үнэлгээ	2,665,213.2	
Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,828.56	-0.90% ▼
MSE I индекс	9,332.39	0.02% ▲
MSE II индекс	7,768.11	-1.05% ▼
Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Монгол шуудан	494,341	311,927,101
Ард санхүүгийн нэгдэл	20,109	31,321,493
АПУ	46,204	28,532,536
Инвескор ББСБ	6,100	15,906,914
Гутал	962	14,672,000
Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол даатгал	214.08	74.89% ▲
Могойн гол	8,855.00	15.00% ▲
Багануур	1,045.00	14.77% ▲
Ариг гал	3,077.00	9.62% ▲
Эрдэнэ ресурс девелопмент	479.48	5.72% ▲
Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Силикат	50.00	-20.63% ▼
Монгол секюритиес	290.00	-14.71% ▼
Булган гурил тэжээл	6500.00	-13.33% ▼
Хэрлэн хивс	39.00	-13.33% ▼
Хөвсгөл алтан дуулга	621.00	-11.29% ▼
Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)	
Ард Секюритиз	684,612,983	
Би Ди Сек	31,605,406	
Дэлгэрхангай секюритиз	30,528,655	
Стандарт инвестмент	29,760,620	
Монгол секюритиес	20,662,913	
Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	615.84	655,366
Таван толгой	6,490.00	341,797
МИК Холдинг	14,940.00	309,397
Говь	258.77	201,870
Инвескор ББСБ	2,656.00	190,509

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

- Үнэт цаасны төлбөр тооцооны T+2 горимд 2020 оны 03-р сарын 31-ний дотор бүрэн шилжинэ гэж СЗХ-ноос мэдээлэв.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны II хуралдаан болж 29 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

- 2019 онд хөрөнгийн зах дээр IPO гаргасан Ард кредит /MSE:ADB/ компани шинэ Гүйцэтгэх захирлаар Монгол шуудан /MSE:MNP/-ийн дэд захирлаар ажиллаж байсан Г.Тэлмэнг томилсон байна.
- Хар хорум пропертийс /MSE:AMT/ компанийн хувьцаа эзэмшигчид хуралдаж, “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг өөртөө нэгтгэхийг зөвшөөрлөө. Ингэснээр тус компани 100 төгрөгийн нэрлэсэн үнэт 15,751,262 ширхэг хувьцааг хаалттай хүрээнд гарган “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлэхээр болсон байна.
- Стандарт ноос /MSE:ALI/ компани 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2020 оны 03 сарын 09-ний өдөр хуралдуулахаар товлон. Хурлаар өнгөрөгч оныхоо үйл ажиллагааны үр дүн, 2020 оны төлөвлөгөө болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хэлэлцэх аж.
- МХБ-ийн үнэт цаасны III ангилалд бүртгэлтэй Хасу мандал /MSE:HSR/ компани 2019 оны санхүүгийн тайлангаа танилцуулсан байна. Компани тайлант хугацаанд 192.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж 16.3 сая төгрөг буюу нэгж хувьцаандаа 52 төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Ашгийн үзүүлэлт өмнөх оноосоо 3 дахин буурсан байна



БУСАД МЭДЭЭ

Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-аас 2019 оны 10-р сарын 18-ны өдрийн ээлжит хурлаар Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад оруулж, хугацаатай үүрэг даалгаврыг 4 чиглэлийн хүрээнд өгсөн.

Энэ үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01-р сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдлаа.

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

- Нэгдүгээр сард 3,558 кг үнэт металл худалдан авлаа.
- Ариг банкны үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна.
- Монголбанк: Төгрөгийн ханшийн сулралт даамжрахаас сэргийлж 100 сая ам.доллар ээлжит бусаар валютын захад нийлүүлээ.
- Төмрийн хүдрийн компаниуд ажилчдаа БНХАУ-д зорчихыг хязгаарлав.
- Уханийн вирусийн тархалтаас болж уул уурхайн компаниудын хувьцааны ханш буурав.



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк 2020 оны 1 дүгээр сард 3,558 кг үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 597 кг үнэт металл худалдан авснаас 2,960 кг-аар их буюу 5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Монголбанк 2020 оны 1 дүгээр сард 3,558 кг үнэт металл худалдсан авсан ба үүнээс 1,747 кг нь цагаан мөнгө, 1,810 кг нь алт байсан. Монголбанк 2020 оны 1 дүгээр сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 61 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 72 кг үнэт металлыг худалдаж авсан байна.

2020 оны 1 дүгээр сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 137,211.81 төгрөг байлаа.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

“Rio Tinto” компанийн хувьцааны ханш даваа гарагийн Европын арилжаагаар тав гаруй хувиар буурлаа. Энэ нь сүүлийн 17 долоо хоногт байгаагүй огцом буурсан дүн болов. Үүний зэрэгцээ Их Британийн “FTSE 100” индекс 1.4 хувиар буурчээ.

Зөвхөн “Rio Tinto” гэлтгүй уул уурхайн салбарын бусад гол тоглогчид болох “BHP Group”-ийн хувьцааны ханш дөрвөн хувиар, “Fortescue Metals”-ийнх 6.9 хувиар буурсан байна. “Vale”-ийн хувьцаа ч мөн унажээ. Шинэ төрлийн “коронавирус”-ийн тархалт, хор хөнөөл нэмэгдэхийн хэрээр БНХАУ-ын эдийн засагт илүү хүнд цохилт болох төлөвтэй байна. Ижил төстэй SARS-ийн халдвар 2003 онд тархаж байсантай харьцуулахад өнөөдөр энэ нь уул уурхайн салбарт илүү том цохилт болно гэж шинжээчид таамаглаж байна.



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.